
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн А/108 тоот тушаалын нэгдүгээр хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.01.20	Хуудасны тоо: 8
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан		Танилцах албан тушаалтнууд: Багш нар	

БАГШИЙН АЖЛЫН ЦАГИЙН АЧААЛАЛ, БАГЦ ЦАГИЙН ЖУРАМ

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: **V1.2026**

Түгээлт



Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	Сургалтын менежер	Лувсандорж Чингэрэл	2025.11.13	
Хянасан	ДЧБСХААжилтан	Энх-Амгалан Шинэжаргал	2026.01.19	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.20	

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ. Нийтлэг үндэслэл	1
ХОЁР. Багшийн багц цагийн тооцох.....	1-2
ГУРАВ. Танхимын болон танхимын бус багц цагийг тооцох	2-8
ДӨРӨВ. Бусад.....	8
ТАВ. Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийг тооцох маяг.....	8



№ Ж-3-005

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехникийн коллежийн багш, тэнхимийн эрхлэгч, сургалтын менежер, арга зүйчийн сургалтын ажлын цагийн ачааллыг ур чадварын түвшинтэй уялдуулан тогтоох, багц цагаар тооцохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг баримтална.

1.2.Багшийн ажил нь боловсролын ерөнхий хууль, Мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын тухай хуульд заасан багшийн үүргийн хүрээнд багшийн ажлын байрны тодорхойлолтоор тодорхойлогдох бөгөөд сургалтын цагийн жилийн ачаалал, цалин, нэмэгдэл хөлс тооцох үндэслэл болно.

1.3.Багшийн сургалтын цагийн ачаалал, багц цаг нь ажлын байрны тодорхойлолт, албан тушаалын зэрэглэл, мэдлэг ур чадварын түвшин, ажлын үнэлгээтэй харилцан уялдаатай байна.

1.4.Сургалтын байгууллагын хичээлийн нэг цаг (цаашид “цаг”)-ийн хэмжээ нь 40 минут байх бөгөөд хоёр цагийн дунд нь завсарлахгүйгээр 80 минутад багтаан явуулахаар хичээлийн хуваарьт тусгана.

1.5.Сургууль дээрх дадлагын сургалтын нэг ээлжид хичээллэх суралцагчийн тоо 15-аас доошгүй байна.

1.6.Үндсэн цалин ба нэг багц цагийн үнэлгээ харилцан хамааралгүй байна.

1.7.Мэргэжлийн болон ерөнхий эрдмийн багшийн ажлын ачааллыг багц цагаар тооцох бөгөөд жилд нэг багш **20 багц** цагийн ажлыг гүйцэтгэнэ.

1.8.Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагаар тооцох үйл ажиллагаа нь үнэн зөв, бодитой, тодорхой, судалгаа, нотолгоонд тулгуурласан хүлээн зөвшөөрөгдөхүйц байна.

Хоёр.Багшийн багц цагийг тооцох

2.1.Багшийн багц цаг нь танхимын ба танхимын бус сургалтын үйл ажиллагааны багц цагаас бүрдэнэ.

2.2.Танхимын сургалтын багц цагт онол /лекц, семинар/, сургууль дээрх дадлага, үйлдвэрийн дадлага сургалт болон төгсөлтийн үйл ажиллагааг хамруулна.

2.3.Танхимын бус сургалтын багц цагт сургалтын үйл ажиллагааг дэмжих, багш мэргэжлийн хөгжлийн сургалт, үйл ажиллагаанд хамрагдах, иргэд, түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах, суралцагчийн хөгжлийг дэмжихтэй үйл ажиллагаануудыг хамруулж тооцно.

2.4.Багш нь тухайн жилд багц цагаа давуулан ажил гүйцэтгэсэн бол нэмэгдэл хөлс олгоно.



№ Ж-3-005

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

2.5.Багш нарын 7 хоногийн цагийн ачааллыг сургалтын албанаас гаргаж, мэдээлэн ачааллыг тэнцвэржүүлэх бодлого барьж ажиллана.

2.6.Нэг багц цагт олгох нэмэгдэл хөлс нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 60 хувиас доошгүй байна.

2.7.Багшийн дутагдал эсвэл багш хүндэтгэн үзэх шалтгаанаар сургалт зохион байгуулах боломжгүй тохиолдолд тэнхимийн эрхлэгч, сургалтын менежер, арга зүйч хичээл зааж болох бөгөөд сургалтын багц цаг нь жилд 8 багц цагаас хэтрэхгүй байна.

2.8.Сургалтын байгууллагын үндсэн орон тоонд ажиллаж байгаа мэргэжлийн багш нар нь ур чадвар, тухайн мэргэжлийн чиглэлээр ажилласан жилд үндэслэн мастер багш, ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 4, ерөнхий эрдмийн багш нь ахлах багш, багш, дадлагажигч багш гэсэн 3 түвшинтэй байна.


2.9.Багш энэ журмын 2.7-д заасан түвшинд үндэслэн ачааллыг дараах байдлаар тооцож мөрдөнө.

Багшийн ур чадварын түвшин	Танхимын сургалтын багц цаг		Танхимын бус сургалтын багц цаг	
	Эзлэх хувь	Жилийн ачааллын багц цаг	Эзлэх хувь	Жилийн ачааллын багц цаг
Мастер багш	80%	16	20%	4
Ахлах багш	85%	17	15%	3
Багш	90%	18	10%	2
Дадлагажигч багш	95%	19	5%	1

2.10.Багшийн ур чадварын түвшинг тухайн мэргэжлийн ур чадвар болон ажилласан жилд үндэслэн ажил олгогч, түншлэгчийн төлөөллийг оролцуулан сургалтын байгууллага тодорхойлно.

Гурав.Танхимын болон танхимын бус сургалтын багц цагийг тооцох

3.1.Багшийн сургалтын нэг багц цагт онолын болон сургууль дээрх дадлага сургалтын хувьд 36 цаг, үйлдвэрлэлийн дадлага болон төгсөлтийн дадлага үйл ажиллагааны хувьд 72 цагийг тооцно.

	№ Ж-3-005 Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

3.2.Багшийн танхимын бус сургалтын нэг багц цагт 72 цагийн сургалтаас гадуурх ажлын гүйцэтгэлийг тооцно.

3.3.Энэ журмын 3.1 болон 3.2 дахь багц цагийг хооронд нь шилжүүлж тооцохгүй.

3.4.Багш нь бусад албан тушаалын чиг үүргийг хавсран гүйцэтгэсэн тохиолдолд жилд гүйцэтгэх багц цагийн ачааллыг 40 хүртэл хувиар хорогдуулж тооцно.

3.5.Багшийн багц цагийн гүйцэтгэлийг сар, улирал, хагас жил, жилээр тооцно.

3.6.Баталгаажуулсан багц цагийн тооцоонд сургалтын байгууллагын захирал хянан баталгаажуулж, санхүүгийн албанд шилжүүлнэ.

3.7.Танхимын бус сургалтын багц цагт хамаарах ажил үйлчилгээ, тооцох цагийн хэмжээ:

№	Танхимын бус сургалтын багц цагийн бүрэлдэхүүн	Хамаарах ажил үйлчилгээ	Хугацаа	Тооцох багц цаг	Танимын бус сургалтын багц цаг тооцох эрх бүхий тушаалтан
1	Сургалтын үйл ажиллагааг дэмжих	Сургалтын байгууллагын сургалт арга зүй, мэргэжлийн болон сургалт арга зүйн зөвлөлөөр зөвшөөрөгдсөн, салбарын тэргүүлэх эрдэмтдийн тодорхойлолт, шүүмж авсан ном сурах бичиг бичиж хэвлүүлсэн, хамтран бичсэн байдал	жил	Үндэсний хэмжээний сурах бичиг бичсэн бол-2, Багт ажилласан бол 1 багц цаг	Сургалтын менежер
		Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын төлөвлөгөө боловсруулсан (багт)	сар	Шинээр-0.5 Шинэчилсэн-0.3	Сургалтын менежер
		Мэргэжлийн стандарт боловсруулах багт ажиллавал	жил	1 багц цаг	Сургалтын менежер
		ЧСС-ын хөтөлбөр, техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулж, баталгаажуулсан бол	жил	Мэргэжлээр (багт)-1 багц цаг Нэгж-0.1 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч



№ Ж-3-005

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

		Сургалтын хэрэглэгдэхүүний боловсруулалт /зурагт болон биет үзүүлэн, слайд, аудио ба видео бичлэг/	сар	Чадамжийн нэгжээр 0.4	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Лаборатори, дадлагын газар, кабинет байгуулсан бол	жил	Шинээр 1 багц цаг, шинэчилбэл 0.3 багц цаг	Сургалтын менежер
		Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажилласан бол	сар	0.05 багц цаг	ХАБЭА ажилтан
		Дадлагын газар, лаборатори, кабинет хариуцсан бол	сар	0.2 багц	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Жижүүр багшийн үүргийг хангалттай сайн гүйцэтгэсэн бол	сар	0.05 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Сургалтын орчин бүрдүүлсэн байдал (ангийн эд хогшлын бүрэн бүтэн байдал, ангийн тохижилт)	сар	0.1 багц цаг	Аж ахуйн менежер
		Бие даасан болон хамтарсан гарын авлага бичиж хэвлүүлсэн бол	улирал	Бие даасан-0.7 багц цаг Хамтарсан-0.3 багц цаг	Сургалтын менежер
		Ном сурах бичиг редакторласан бол	жил	0.2 багц цаг	Сургалтын менежер
		Зөвлөмж, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл бичиж нийтлүүлбэл (гадаад, дотоодод сонин сэтгүүл эрдэм шинжилгээний бичигт)	жил	Дотоодод-0.5 багц цаг Гадаадад-0.7 багц цаг	Сургалтын менежер
2	Багш, мэргэжлийн хөгжлийн сургалт үйл ажиллагаанд хамрагдах	Олимпиад, мэргэжлийн уралдаанд багш өөрөө болон суралцагч амжилт гаргасан бол	Хагас жил	Олон улсад байр эзэлбэл-2 багц цаг, оролцвол-0.2 багц цаг, Улс: 1-р байр 1.5 багц, 2-р байр 1 багц, 3-р байр 0.8 багц цаг Бүс (хот, аймаг, дүүрэг) 1-р байр 0.8 багц цаг багц,	Сургалтын менежер



№ Ж-3-005

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам


Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

				2-р байр 0.6 багц, 3-р байр 0.4 багц цаг Улс, бүсийн тэмцээнд тусгай байр эзэлсэн бол 0.1 багц цаг Улс бүсийн тэмцээнд оролцвол-0,05 багц цаг СУРГУУЛЬ 1-р байр 0.3 багц, 2-р байр 0.2 багц, 3-р байр 0.1 багц цаг	
		Эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хуралд илтгэл тавьж амжилттай оролцсон байдал	жил	Улс: 1-р байр 1 багц, 2-р байр 0.8 багц, 3-р байр 0.6 багц цаг Бүс (хот, аймаг, дүүрэг) 1-р байр 0.5 багц цаг багц, 2-р байр 0.4 багц, 3-р байр 0.3 багц цаг Улс, бүсийн тэмцээнд тусгай байр эзэлсэн бол 0.2 багц цаг Улс бүсийн тэмцээнд оролцвол-0.1 багц цаг СУРГУУЛЬ 1-р байр 0.3 багц, 2-р байр 0.2 багц, 3-р байр 0.1 багц цаг	Сургалтын менежер

	№ Ж-3-005 Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

				Сургуульд оролцсон бол 0.05 багц цаг	
		Сургалтын байгууллага, сургалтын үйл ажиллагааны чиглэлээр судалгаа, шинжилгээний ажилд оролцож, шинжилгээний ажилд оролцож патент авбал	жил	1 багц цаг	Сургалтын менежер
		Тухайн жилд докторын зэрэг хамгаалсан бол	жил	Бүтээлийн чөлөө аваагүй бол-2б/ц Бүтээлийн чөлөө авсан бол 0.5 б/ц	Сургалтын менежер
		Баримт бичиг, судалгаа мэдээлэл, бүртгэл хөтлөлт	сар	0.06 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Сургуулийн захиргаанаас өгсөн ажил үйлчилгээ, үүрэг даалгаврыг амжилттай сайн (үүрэг даалгаврын хуудсыг үндэслэн) гүйцэтгэсэн бол	сар	1 багц цаг	Захирал
		Багш нь онлайн сургалт зохион байгуулсан бол	сар	0.2 б/ц	Сургалтын менежер
		Багш нь үндсэн мэргэжлээрээ бие даан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн бол	сар	Баримтыг үндэслэн 0.4 багц цаг	Сургалтын менежер
		Баг ахалж амжилттай ажилласан (сар, жилийн ажлын төлөвлөгөө, ажлын үр дүнг харгалзсан) бол	сар	0.1 багц цаг	Сургалтын менежер
3	Иргэд, түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах	Бусад байгууллагаас зохион байгуулсан ажил, тэмцээн уралдаанд багш /бэлтгэсэн суралцагч /шагналт байранд шалгарсан байдал (СА-аас зөвшөөрсөн)	сар	0.1 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Сургалтын байгууллага нэр дээр төсөл боловсруулж, хэрэгжүүлсэн бол	Хагас жил	1бц 0.5 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Ажил үйлчилгээ гүйцэтгэх замаар сургуульд оруулсан ашгийн 600 мянган төгрөг тутамд	сар	1 багц цаг	Нягтлан



№ Ж-3-005

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам


Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

4	Суралцагчийн хөгжлийг дэмжих	Анги хамт олноо сурлага хүмүүжлийн зөрчилгүй хариуцан ажилласан байдал	сар	0.2 багц цаг	Нийгмийн ажилтан
		Сургалтын байгууллага, суралцагчийн зөвлөл, хамт олны зохион байгуулсан ажил, тэмцээн уралдаанд анги хамт олноо удирдан оролцож, шагналт байранд шалгарсан байдал	сар	0.03 багц цаг	Нийгмийн ажилтан
		Сургалтын албаны зөвшөөрлөөр дугуйлан секц, сонгон удирдаж, амжилттай зохион байгуулсан байдал	Хагас жил	0.5 багц цаг	Сургалтын менежер
		Хөндлөнгийн үнэлгээгээр сурлагын чанарт ахиц гарсан байдал	улирал	0.3 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Суралцагч, багш, хамт олны дунд семинар, уралдаан, тэмцээн зохион байгуулж, санаачилгатай ажилласан байдал	сар	0.1 багц цаг	Сургалтын менежер
		Тэгш хамран сургах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажилласан бол	сар	0.1 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
		Багш нь суралцагчаа гарааны бизнес эрхлүүлсэн, суралцагчаа хөгжүүлэх замаар шинэ санаа, бүтээл хамтран гаргасан бол	жил	0.3 багц цаг	Сургалтын менежер
	Багш нь төгсөгчдийг ажлын байраар хангасан бол /нотлох баримтаар/	жил	Нэгж ажлын байр нь 0.01 багц цаг	Нийгмийн түншлэл хариуцсан ажилтан	
	Багш нь суралцагчийн хяналтын графикийг (давтлага, зөвлөгөө өгөх, бие даалт тооцож, явцын шалгалт авах) тогтмол мөрдөж ажилласан байдал	жил	0.1 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч	

	№ Ж-3-005 Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журам Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд	Баталсан огноо: 2026-01-20 Хувилбар: V1.2026 Нууцын зэрэг: Нээлттэй
---	---	---

	Бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтад бэлтгэх давтлага өгсөн	жил	1 ангид 0.1 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
	Курсын болон график тооцооны ажил удирдсан болон хамгаалуулсан бол	сар	1 суралцагчид 0.03 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч
	Дипломын төсөл удирдсан бол	сар	1 суралцагчид 0.15 багц цаг	Арга зүйч, тэнхимийн эрхлэгч

Дөрөв.Бусад

4.1.Үндсэн багшийн эзгүйд тодорхой шалтгааны улмаас нөхөн, орлон хичээл заасан бол холбогдох багц цагийн хөлсийг нэг багц цагийн үнэлгээний 70 хувиас ихгүй байхаар тооцож олгоно.

4.2.Гадны багш, инженер, техникийн ажилтныг цагаар ажиллуулсан тохиолдолд сургалтын ажил гүйцэтгэх гэрээ байгуулж, нэг цагийн хөлсийг хөдөлмөрийн доод хэмжээний 4 хувиас ихгүй байхаар тооцно.

4.3.Танхимын ба танхимын бус сургалтын ажлын ногдол багц цагийг хүндэтгэх бус шалтгааны улмаас биелүүлээгүй нөхцөлд гүйцэтгэсэн багц цагийн хөлсийг тухайн багц цагт харгалзах хэмжээгээр багшийн цалин хөлснөөс хасаж тооцно.

4.4.Мэргэжлийн болон техникийн, бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтын комиссын гишүүний цагийн гүйцэтгэл нь 50 цагаас ихгүй байх бөгөөд нэг цагийн хөлс нь хөдөлмөрийн доод хөлсний доод хэмжээний 5 хувиас ихгүй байна.

4.5.Багц цагийг тооцохдоо “Жендэрийн эрх тэгш байдлыг тухай” хуулийн 11.6.1 дэх заалтыг мөрдлөг болгон ажиллана.

4.6.Танхимын бус багц цагийн гүйцэтгэлийг маягтын дагуу тайлагнана.

4.5.Энэхүү журмыг зөрчсөн аливаа үйл ажиллагаанд холбогдох хуулийн дагуу буруутай этгээдэд хариуцлага тооцно.

Тав.Хөтлөгдөх маягт

5.1. СА-М-7-026 - Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийг тооцох маягт



№СА-М-7-026

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журмыг дүгнэх маяг
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

БАГШИЙН АЖЛЫН ЦАГИЙН АЧААЛАЛ, БАГЦ ЦАГИЙН ЖУРМЫГ ДҮГНЭХ МАЯГТ

Шалгуур	Хийж хэрэгжүүлсэн ажил	Дүгнэх ажилтан	Авбал зохих дээд оноо	Авсан оноо	Дүгнэсэн ажилтны гарын үсэг	
Сургалтын үйл ажиллагааг дэмжих	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын төлөвлөгөө боловсруулсан (багц)	Сургалтын менежер	0.5			
	ЧСС-ын хөтөлбөр, техникийн боловсролын сургалтын хөтөлбөр боловсруулж баталгаажуулсан бол	ТХАЗ	0.1			
	Сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулалт зурагт болон биет үзүүлэн, слайд, аудио, видео	ТХАЗ	0.4			
	Лаборатори дадлагын газар байгуулсан бол	Сургалтын менежер	0.3-1			
	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйг хангаж ажилласан бол	ХАБЗА ажилтан	0.05			
	Дадлагын газар, лаборатори, кабинет хариуцсан бол	ТХАЗ	0.2			
	Жижүүр багшийн үүрэг хангалттай сайн гүйцэтгэсэн байдал	ТХАЗ	0.05			
	Сургалтын орчин бүрдүүлсэн байдал (ангийн эд хогшлын бүрэн бүтэн байдал, ангийн тохижилт)	ЗАА менежер	0.1			
		Сургалтын төлөвлөгөөг боловсруулсан бол-0.5 Шинэчилсэн бол-0.3				
		Нэгж бүрээр хийсэн боловсруулсан бүртгэл /жил/				
	Ээлжит хичээл бүрээр шинэчилсэн бол 0.05 Шинээр хийсэн бол 0.1 Тухайн сарын зохион байгуулсан ээлжит хичээл бүрээр хийсэн бол 0.4 Шинээр хийсэн бол 1 Шинэчилсэн бол 0.3					
	Тусгай чак листээр					
	Кабинет лабораторийн хавтас, хөтөлгөө, төлөвлөгөө, үзүүлэн тараах материал байгаа бол					
	Жижүүр багш цаг бүрт ирцийг авч ажилласан бол-0.01 Түүний мөрөөр ажилласан бол-0.01 Тухайн өдрийн тэмдэглэлийг сайн бөглөсөн бол-0.01 Өгсөн үүрэг даалгаврыг сайн биелүүлсэн бол-0.02					
	ЗАА менежер тусгай шалгуураар					

<p>Багш, мэргэжлийн хөгжлийн сургалт үйл ажиллагаанд хамрагдах</p>	<p>Бие даасан болон хамтарсан гарын авлага бичиж хэвлүүлсэн бол /улирал/ Олимпиад, мэргэжлийн уралдаанд багш өөрөө болон суралцагч амжилт гаргасан бол Эрдэм шинжилгээ, онол, практикийн бага хуралд илтгэл тавьж амжилттай оролцсон бол Баримт бичиг, судалгаа мэдээлэл, бүртгэл хөтлөлт Сургуулийн захиргаанаас өгсөн ажил үйлчилгээ, үүрэг даалгаврыг амжилттай сайн (үүрэг даалгаврын хуудсыг үндэслэн) гүйцэтгэсэн бол Багш нь онлайн сургалт зохион байгуулсан бол Багш нь үндсэн мэргэжлээрээ бие даан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн бол /үндсэн сургалт, бие даан мэргэжил боловсролоо дээшлүүлсэн бол/ Сургалтын байгууллага, төсөл хөтөлбөр, яам, түүний харьяа байгууллагын төлөвлөсөн сургалт хамаарахгүй/</p>	<p>Хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн багш нар болон суралцагч хэрэглэх боломжтой /улирал/ Бие даасан-0.7, хамтарсан-0.3 БШУС-ын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 103 тоот тушаалд зааснаар БШУС-ын 2024 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 103 тоот тушаалд зааснаар Журнал хөтлөлт, цаг үеийн судалгаа хугацаанд нь бөглөсөн бол, онлайн сургалтын ирц бүртгэл зэргийг тооцож оноожуулна. Захирал өгсөн үүрэг даалгаврын дагуу Төлөвлөгөө боловсруулсан бол-0.1 Хичээл явуулсан бол-0.2 Үндсэн сургалтад суусан бол-0.1 Бие даан өөрийн санаачилгаар сургалтад сууж, сертификаттай болсон бол-0.1</p>	<p>Сургалтын менежер СА менежер Сургалтын менежер ТХАЗ Захирал Сургалтын менежер Сургалтын менежер</p>	<p>0.3-0.7 0.06 1 0.2 0.4</p>	<p>Иргэд, түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах</p>	<p>Сургалтын менежер Нийгмийн түншлэл үйлдвэр сургалт хариуцсан арга зүйч</p>	<p>Сар, жилийн ажлын төлөвлөгөө болон бусад үйл ажиллагаанд баг ахалж оролцсон бол үр дүнг харгалзан 0.1 Салбарын тэмдэглэлт баяр, арга хэмжээ, салбараас зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсон бол</p>	<p>0.1 0.1</p>
---	--	--	--	--	---	---	--	--------------------



№СА-М-7-026

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журмыг дүгнэх маягт

Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20

Хувилбар: V1.2026

Нууцын зэрэг: Нээлттэй

Суралцагчийн хөгжлийг дэмжих	Иргэд, түншлэгч байгууллагуудтай хамтран ажиллах /нийгмийн түншлэлтэй холбогдолтой баримт бичиг, судалгаа, мэдээлэл өгсөн байдал/	Танилцах болон үйлдвэрлэлийн дадлагад суралцагчдаа бүрэн хамруулсан ирц, нотлох баримт цаг тухай бүр бүрдүүлж тайлагнасан байдал	Нийгмийн түншлэл үйлдвэр сургалт хариуцсан арга зүйч	0.1	
	Анги хамт олноо сурлага хүмүүжлийн зөрчилгүй хариуцан ажилласан байдал /суралцагчийн ирц, идэвх, явцын байдал/	Суралцагчийн ирцийн мэдээллийн хувиар тооцож үнэлэх-0.1 Тасалсан суралцагчтай ажилласан байдал-0.1	нийгмийн ажилтан	0.2	
	Сургалтын байгууллага, суралцагчийн зөвлөл, хамт олны зохион байгуулсан ажил, тэмцээн уралдаанд анги хамт олноо удирдан оролцож, шагналт байранд шалгарсан бол	Оролцосон бол 0.01 Шагналт байранд орсон бол 0.03	нийгмийн ажилтан	0.03	
	Сургалтын албаны зөвшөөрлөөр дугуйлан секц, сонгон удирдаж амжилттай зохион байгуулсан бол Даан ажиллаж буй ангийн ачаалал /2-оос дээш анги/	Секц дугуйлангийн төлөвлөгөө, хэрэгжилт, хийсэн ажил-0.2 Даасан ангийн суралцагчийн тоо, ачаалал-0.5 хүртэл	Сургалтын менежер	0.5	
	Хөндлөнгийн үнэлгээгээр сурлагын чанарт ахиц гарсан байдал	Багшийн үнэлгээ болон хөндлөнгийн үнэлгээг харьцуулж гаргах	ТХАЗ	0.3	
	Суралцагч, багш хамт олны дунд семинар, сургалт, уралдаан зохион байгуулж идэвх санаачилгатай ажилласан бол	Багш санаачлан төлөвлөгөө боловруулж батлуулсан бол Суралцагчдад сургалт семинар зохион байгуулсан баримт нотолгоо, үйл ажиллагааны ирц, идэвх	СА менежер	0.1	
	Тэгш хамран сургах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажилласан бол	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллах төлөвлөгөөтэй бол, төлөвлөгөөний дагуу ажилласан бол	ТХАЗ	0.1	
	Багш нь төгсөгчийг ажлын байраар хангасан бол /нотлох баримтаар/	Нэгж ажлын байр-0.01	Нийгмийн түншлэл үйлдвэр сургалт хариуцсан арга зүйч		



№СА-М-7-026

Багшийн ажлын цагийн ачаалал, багц цагийн журмыг дүгнэх маягт
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн санд

Баталсан огноо: 2026-01-20
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

Багш нь суралцагчийн хяналтын графикийг (давтлага, зөвлөгөө өгөх, бие даалт тооцож, явцын шалгалт авах) тогтмол мөрдөж ажилласан байдал	Хичээл зааж буй анги бүрээр явцын шалгалт авч, матриц хийж, дүгнэлт гарган дүн шинжилгээ хийсэн бол	ТХАЗ	0.1	
Бүрэн дунд боловсролын төгсөлтийн шалгалтад бэлтгэх давтлага өгсөн /1 анги/	1 ангид 0.1 кр	ТХАЗ		
Курсын болон график тооцооны ажил удирдсан бол	1 суралцагч 0.03	ТХАЗ		
Дипломын төсөл удирдсан бол	1 суралцагч 0.15	Сургалтын менежер		
Нийт тооцсон багц цаг			6.21	
Ажлын гүйцэтгэлийн хувь			100	

ХЯНАСАН:
ЗАХИРАЛ

Ч.ЭРДЭНЭТУЯА

НЭГТГЭСЭН:
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Л. ЧИНГЭРЭЛ